



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/341

Мөрөн сум

Хурдан морины уралдаан товлон
зарлах, зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдөөс ирүүлсэн хүсэлтийн дагуу Шишгэд бүсийн сумдад зохион байгуулагдах “Дэлгэрхaan уулын их тахилга”, “Цагаан адууны баяр”, “Дархад их хурд-7” хурдан морины уралдааныг (зургаан нас) Улаан-Уул суманд 2023 оны 08 дугаар сарын 02-ноос 04-ний өдрүүдэд аймгийн бүсийн зэрэглэлтэй зохион байгуулахыг Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумын удирдлагууд, аймаг сумын уяачдын холбоодод тус тус даалгасугай.

2. Шишгэд бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулагчийн зүгээс онцгой анхаарч, холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (хурандаа А.Алтанцоож), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), холбогдох сумдын Засаг дарга, аймгийн “Дэлтэй цэнхэр морин спорт уяачдын холбоо”, аймгийн үндэсний бөхийн холбоо, Улаан-Уул сумын “Дэлгэрхaanы хурд морин спорт уяачдын холбоо”, сумдын салбар холбооны удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



6712010713